

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

№02

Засгийн газрын 8 дугаар байр  
Олимпийн гудамж – 2  
Сүхбаатар дүүрэг 14120  
Монгол Улс  
Утас: 264269

## Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13, 25.14 дах хэсэг, “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 3.2.3.2, 3.2.4, 3.5 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дараах 4 байгууллагын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг нийт 4 үндсэн мэргэшлийн чиглэлээр 4 жилийн хугацаагаар тус тус сунгахыг зөвшөөрсүгэй.

№	Сургалт эрхлэх байгууллага	Үндсэн мэргэшлийн чиглэл
1.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	1. Яаралтай тусламж судлал
2.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	1. Мэс засал судлал
3.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	1. Сэргээн засал судлал
4.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	1. Монголын уламжлалт анагаах ухаан судлал

2. Дээрх 4 сургалт эрхлэх байгууллагад үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг үндсэн мэргэшлийн чиглэл тус бүрээр холбогдох журмын дагуу баталгаажуулж олгох, сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл сунгасан чиглэл тус бүрийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн болон шинээр боловсруулж, холбогдох Мэргэжлийн салбар зөвлөлд танилцуулж, батлуулан үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөний хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Т.Мөнхсайхан/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Энхболд/, Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн /Ч.Чимэдрагчаа/-д, үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг 2020 оны 03 дугаар улиралд багтаан Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

4. Эрүүл мэндийн яам, Япон Улсын ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын анхан ба хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-тэй хамтран “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт”-ыг улсын хэмжээнд шат дараатай зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Я.АМАРЖАРГАЛ

